

## Ёс зүйн боловсролын асуудалд

Р.Дарьхүү - МУИС, НШУС.Философийн тэнхмийн эрхлэгч, профессор

Б.Оюунцэцэг - Япон улсын Нихон их сургуулийн докторант

**Түлхүүр үг:** ёс суртахууны хөгжил, зөв амьдрал, биеэ авч явах ёс, ёс суртахууны хэм хэмжээ, иргэний ёс зүй.

Энэхүү өгүүлэлд дэвшүүлж буй гол асуудал нь өнөөгийн нийгмийн болон хувь хүний бодит хэрэгцээ шаардлагын үүднээс ёс суртахууны хөгжил, төлөвшлийн үндэс болсон ёс зүйн боловсролыг эн тэргүүнд авч үзэх, улмаар ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн боловсролын тогтолцооны агуулгыг дэлхийн жишигт нийцүүлэн эрс шинэчлэх арга замын тухай асуудал юм. Учир нь өнөөдөр дэлхий нийтээр хүний хөгжилд анхаарлаа хандуулж, улс орны хөгжлийг хүний хөгжлөөр дүгнэж байна. Хүний хөгжил нь зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмжигдэхгүй, сэтгэлийн боловсролоор хэмжигдэнэ. Тэгвэл сэтгэлийн боловсролыг олгоход ёс зүйн боловсрол чухал үүрэгтэй. Иймд бид юуны өмнө энэ асуудлаархи өөрийн орны өмнөх туршлага ба бусад орны ёс зүйн боловсролын тогтолцоо ба агуулгыг харьцуулан судалж, өнөөгийн монголын бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн ёс зүйн боловсролын тогтолцоо, шинэ агуулга, арга зүйг боловсруулах хэрэгтэй байна.

Ёс суртахууны хөгжил, төлөвшил бол хүн сайн сайхан амьдрахад нэг чухал хүчин зүйл юм. Ёс суртахууны хөгжил нь хүүхдийн ёс суртахууны сонголтыг өргөжүүлэх, өөрөөр хэлбэл, ёс суртахууны чадвар, чадавхийг дээшлүүлэх үйл явц мөн. Ёс суртахууны хөгжил нь догматик сургаал бус, үүнийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой зүйл билээ. Хүний ёс суртахууны үйл ажиллагааг сайжруулах, ёс суртахууны ухамсар, соёлыг дээшлүүлэх замаар ёс суртахууны хөгжлийг хангах учиртай. Гэтэл манайд ёс зүйг хэт ерөнхий утгаар хэрэглэх тусам хүмүүст тодорхой бус, ойлгомжгүй байдлыг үүсгэж буй тал байна. Ёс зүй гэхээр зарим хүмүүс шашны номлол мэтээр ойлгох ч байдаг. Иймээс ёс зүйн талаар зөв тодорхой ойлголтыг өгөхөд ёс зүйн боловсролын тогтолцоо, ёс зүйн боловсролын агуулгыг оновчтой болгох асуудлыг судлах, шинэчлэх нь тулгамдсан асуудал болж байна.

Ёс зүйн боловсролын гол зорилго бол ёс суртахууны хувьд боловсорсон хүнийг төлөвшүүлэх явдал юм. Ёс суртахууны хэм хэмжээ, зарчмуудыг ойлгон ухаарч, хувийн болон нийгмийн амьдралдаа ёс суртахууны хариуцлагатай ханддаг хүнийг ёс суртахууны хувьд боловсорсон хүн гэж үзэж болно. Хүүхдэд эн тэргүүнд байх ёс суртахууны чадвар гэвэл бусдыг зөв ойлгох, бусдын сайн талыг олж харж суралцах, бусадтай зөв харилцах, хүний сул талыг ашиглахгүй байх, бусдад санаа тавих, туслах зэрэг зөв амьдрах арга чадвар болно. Зөв амьдрах арга чадвар нь өргөн агуулгатай ойлголт юм. Энэ талаар эрт үеийн гүн ухаантан нараас эхлээд эдүгээ цагийн олон ухаантан мэргэд тайлбарлаж иржээ.

Дорно дахины гүн ухаанд хүний ёс суртахууны төлөвшлийн асуудал томоохон байр суурь эзэлдэг. Нэг жишээ хэлэхэд, буддизмд аливаа хүн зовлонгоос ангижрах арга зам нь зөв үзэл, зөв бодол, зөв үг, зөв үйл, зөв амьдрал, зөв тэмүүлэл, зөв сэтгэл, зөв бясалгал гэж үздэг. Эдгээр нь хувь хүн биеэ зөв авч явах, зөв амьдрах ёс суртахууны үндсэн зарчмууд юм. Хүүхдэд аль болох багаас нь зөв, сайн үйлийн тухай ойлголтыг өгөх хэрэгтэй. Энэ үйл хэрэгт цэцэрлэгийн наснаас эхлэн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ёс зүйн боловсролыг чанартай, үр өгөөжтэй арга, хэлбэрээр олгох ёстой. Өнөөдөр монголд хүүхдэд ийм боловсролыг өгч чадахгүй байна. Үүнээс болж хүүхдийн ёс суртахууны хөгжил, төлөвшил тун хангалтгүй, хүүхдүүд элдэв гэмт хэрэг болон ёс бус зүйлд татагдаж байгаа баримт олон буй.

Өнөөгийн монголын нийгмийн амьдралын үнэт зүйлсийн агуулга, чанарт гарч буй хувьсал өөрчлөлттэй уялдан хүүхдийг сайн хүн болгон төлөвшүүлэхэд ёс зүйн боловсролын үүрэг ач холбогдол улам нэмэгдэж байгаатай Та санал нийлэх бизээ. Монгол улс 1992 онд шинэ үндсэн хууль баталж, ардчилсан нийгэм байгуулж эхлээд 18 жилийн нүүр үзэж байна. Энэ хугацаанд боловсролын салбарт шинэ стандарт хэрэгжиж эхлээд удаагүй байгаа.

Энэхүү стандартад "иргэнийг оюун ухаан, ёс суртахууны чадавхтай болгон төлөвшүүлнэ" хэмээн заасан байдаг ч бодит байдалд суралцагчдын ёс суртахууны төлөвшил, тэдний эрэлт хэрэгцээ, бидний сэтгэлийг зовоосон ёс суртахууны олон асуудлыг нэгтгэн дүгнэж, сургалт хүмүүжлийн ажлаар хүүхдийн ёс суртахууны төлөвшлийг сайжруулах ёс суртахууны хэм хэмжээг тусгайлан боловсруулж, түүнийг хэрхэн ямар аргаар зааж, тэдэнд хүргэх ёс зүйн боловсролын тогтолцоо Монголд хараахан бүрдээгүй байна гэж хэлж болно. Өнөөдөр ЕБС-уудад сургалтын төлөвлөгөөндөө суралцагчдад зайлшгүй төлөвшүүлэх хэм хэмжээ бүхий ёс зүйн

боловсролын хөтөлбөрийг сургуулийн хэмжээндээ тусгайлан боловсруулсан нь хэр олон байдаг бол. Энэ бол тэдгээр сургуулиудын буруу биш юм.

Энэ нь Монгол улсын боловсролын нэгдсэн тогтолцоонд ёс зүйн боловсролын асуудлыг тодорхой сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой. Иймд ёс зүйн боловсролын талаар БСШУЯ, төрийн бус байгууллага, эцэг, эх, эрдэмтэн судлаачид, багш нар ер нь бүх хүмүүс хамтран ажиллаж, ЕБС-ийн ёс зүйн боловсролын тогтолцоог эрс шинэчлэх цаг болжээ.

Монголчуудын хувьд эрт цагаас ёс зүйн боловсролыг үр хүүхэддээ ардын аман зохиол, үлгэр, домог, зүйр цэцэн үг, ажил хөдөлмөр, ардын зан үйлээр олгож ирсэн түүхтэй. Мөн бидний өвөг дээдэс “Оюунтүлхүүр”, “Монголын нууц товчоо”, “Чингисийн билиг сургаал”, “Тоть шувууны сургаал”, “Авах гээхийн дөрвөн мөрт”, “То вангийн сургаал” зэрэг олон бүтээлүүдэд ёс суртахууны хүмүүжил төлөвшлийн чухал асуудлуудыг гүнзгий тайлбарласан буй. Харамсалтай нь эдүгээ тэдгээр бүтээлийн эерэг үзэл зарчмыг баримтлах нь байтугай мэдэх хүн цөөрсөөр байна.

Монгол улсын “Бага, дунд боловсролын тухай” хуулинд энэ талаар заахдаа: “... хүмүүнлэг, үндэсний дэвшилтэт ёс заншил, ёс суртахууны соёлыг эзэмшүүлж, эх оронч, хууль ёсыг дээдэлдэг үзэл төлөвшүүлнэ” хэмээн бичжээ. Энэ зорилтыг хэрэгжүүлэх үүднээс 1996 онд ЕБС-ийн бага ангид “Ариун ёс”, 1998 оноос ЕБС – ийн Ү ангид “Ёс зүй” гэсэн хичээл зааж, тэр хичээлд хэрэглэх анхны гарын авлага, сурах бичиг хэвлэгдэж байсан билээ. Эдгээр ном сурах бичиг нь тухайн үедээ ЕБС-д ашиглах ёс зүйн боловсролын сурах бичиг, гарын авлагын үүрэг гүйцэтгэж байв. Тэдгээр ёс зүйн сурах бичгийг бэлтгэхдээ өрнө, дорнын ёс зүйн чиглэлээр хэвлэгдсэн судалгааны бүтээлүүд, Монгол ёс заншлын их, бага, тайлбар толь, “Оюунтүлхүүр” зэрэг эх сурвалжийг ашиглаж бичсэн байдаг. Мөн ёс суртахууны хэм хэмжээний талаар үлгэр домог, зүйр цэцэн үг, мэргэдийн сургаал, шүлэг ашиглаж тайлбарлахын зэрэгцээ ёс зүйн судлагдахууны тухай ойлголт, ёс суртахууны сургаалын үүсэл хөгжлийн тухай тухайлбал, эртний үе, дунд үе, шинэ үе, германы сонгодог ёс зүйн хөгжлийн түүхэн үе, гол төлөөлөгчид, үзэл баримтлал, ёс зүйн шинжлэх ухааны талаар тайлбарлаж бичсэн буй.

Сүүлийн жилүүдэд “Ариун ёс” болон “Ёс зүй”-н бие даасан хичээл сургалтаас бүрмөсөн хасагдаж, оронд нь эрх зүйн мэдлэг олгоход илүүтэй анхаарч, бага, дунд, ахлах сургуульд эрх зүйн хичээлүүд түлхүү орох болсон

байна. Ийнхүү эрх зүйн хичээлд хүүхдийн эрх, үүргийн талаар түлхүү заах болсон нь нэг талаар сургуулиас завсардсан хүүхдүүд олширч, тодорхой зорилгогүй тэнүүчлэх, гэр орноосоо дайжих, гэмт хэрэгт холбогдох явдал ихээр гарах болсонтой холбоотой байж болох юм. Тухайлбал, ЕБС – ийн IY ангийн сурах бичигт, ажил хийдэггүй аав нь охиноо гуйлга гуйлгуулахаар зах руу явуулдаг тухай жишээ татаад хүүхдийн ямар эрх зөрчигдөж байгаа тухай, хүүхдийн эрхийг хамгаалах ямар хуулийн заалт зөрчигдсөн талаар ярилцдаг байна. Энэ үеэс “хууль бидний амьдралд”, “хүний эрхийн боловсрол” хэмээх үгс түгээмэл хэрэглэгдэх болж сурагчид YI ангидаа ардчилал дахь улс төрийн эрх, нийгэм эдийн засаг дахь соёлын эрх, хүний эрхийн талаар үздэг байна. Эдгээр хичээлийн зарим сэдэв нь сурагчдад хэт хүнд, мэргэжлийн ангийн оюутан, судлаачдад таарахуйц агуулгатай байдаг. Тухайлбал, цаазаар авах ял хэрэгтэй эсэх, шоронгийн нөхцөл, шүүхийн үйл ажиллагааны талаар YI ангидаа үздэг байна. Гэр бүлийн гишүүдийн эрхийн тухай заахдаа хүүхдийн эрхийн конвенци, хүний эрхийн баримт, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн зүйл ангийн талаар заадаг жишээтэй.

Гэвч зөвхөн хуулийг ийм байдлаар зааснаар хүүхэд ямар түвшний ёс зүйн боловсрол олж авах вэ. Хуулийг сахиж дээдлэх нь эрхэм чухал зүйл боловч хуулинд бичигдээгүй, хүмүүсийн хоорондын ёс суртахууны харилцаа, нийгмийн үнэт зүйлс гэж бий. Хүмүүс өдөр тутмынхаа амьдралд эрх зүйн төдийгүй ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгодог. Эрх зүйн боловсролоос ач холбогдлын хувьд дутахгүй чухал боловсрол бол ёс зүйн боловсрол мөн. Учир нь ёс зүйн боловсрол нь хүн ёс, хүн төрхийг хүүхдэд олгодог боловсрол билээ.

Гэтэл шилжилтийн үед ийм чухал боловсролыг үл тоомсорлон орхигдуулж, хүн ёсны харилцаа, нийгмийн харилцааг бүгдийг хуулиар зохицуулах гэсэн хандлага нь буруу байна. Амьдрал дээр ёс зүй нь зарим тохиолдолд хуулиас ч түгээмэл, урт хугацааны туршид нийгэмд оршин тогтносоор ирсэн бөгөөд хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг ёс суртахууны бичигдээгүй хууль байдаг. Өнөөдөр ёс зүйн хэм хэмжээний талаар “Иргэншил”, “Хүн–орчин”, “Эрүүл мэнд” зэрэг зарим хичээлийн хөтөлбөрт хавсарга сэдэв болгон зааж байна. Эдгээр хичээлүүдийн заах арга сайжирч, тухайн сэдвийн талаар хүүхдүүд хоорондоо ярилцах цаг гаргах талаар анхаарч, сурах бичгүүдэд олон зураг өнгөт хэвлэл ашиглах болсон нь сайн хэрэг юм.

Гэхдээ ёс зүйн талаар зааж байгаа сэдвийн агуулга, заах арга зүйн талаар эргэцүүлэн бодох анхаарах зүйл их байна. Ийнхүү бусад хичээлийн

агуулгад хавсрага болгон зааж байгаа нэрийдлээр ёс зүйн боловсролыг хоёрдугаарт тавих нь том алдаа юм. Учир нь ийм хэлбэрээр ёс зүйг заах нь "хоёрдогч"сэдэв болж хувирахад хүргэж байгаа болно. Жишээ нь, эрүүл мэнд хичээлээр уур уцаарын тухайн зааж буй хэсгийг харахад, хүмүүсийн харьцааны талаар гэхээсээ илүүтэйгээр биологийн талаас нь голлон тайлбарласан харагддаг. Уур уцаар бие тархинд муу, уурын үед бие организмд ямар нөлөө үзүүлэх талаар бичсэн байдаг. Энэ сэдэв нь хүмүүсийн харьцааны талаар заахад хангалттай байж чадахуу.

Өнөөдөр ЕБС-уудад ёс зүйн боловсрол хангалттай бус хэмээн үзэх өөр нэг үндэслэл бол математикийн боловсролын хөтөлбөр гэж байдаг атлаа ёс зүйн боловсролын хөтөлбөр гэсэн бие даасан зүйл байдаггүй. Мөн түүнчлэн манай улсад ёс зүйн боловсролын сургалтын стандарт, ёс зүйн сургалтын бие даасан хөтөлбөр, багш нарт зориулсан сурах бичиг, гарын авлага, тусгай сургалт, хариуцсан багш, мэргэжилтэн гэж байдаггүй. Ийнхүү энэ талаар нэгдсэн системтэй бодлого байхгүй тул ёс зүйн талаар заах хичээлийн агуулга, сэдэв хоорондын холбоо хамаарал дутмаг хангалтгүй байна. ЕБС-ийн багш нараас суралцагчдын ёс суртахууны төлөвшлийн талаар анкетийн судалгаа авахад, ихэнх хүүхдүүд ёс суртахууны харилцааны тал дээр дутагдалтай, хараалын үг их хэрэглэдэг, бие биенээ хүндэлдэггүй, бусдыг ялгаварлан гадуурхадаг, хүний үг сонсож чаддаггүй, түргэн ууртай, сургуулийн эд үйлсэд өөриймсөг ханддаггүй зэрэг ёс суртахууны олон сөрөг зүйл байгаад сэтгэл зовниж байгаагаа бичсэн байв. Мөн ёс суртахууны талаар заадаг сэдвүүдийн агуулга нь суралцагчдын үзэл бодол, санаа сэтгэгдэл өөрчлөгдөж, хөгжихэд нөлөөлөхөд хангалттай биш гэж анкет судалгаанд оролцсон дийлэнх багш нар үзжээ.

Бид ёс зүйн боловсролын тогтолцоо, агуулга, заах арга зүй гэсэн гурван чиглэлээр БНСУ, Япон, БНХАУ-ын ёс зүйн боловсролын талаар судалгаа хийж байгаа юм. Ёс зүйн боловсролын асуудлыг шийдвэрлэхэд эдгээр орнуудын туршлагаас суралцах зүйл багагүй бий. Энд бид механикаар бусад орны туршлагыг шууд хуулбарлах бус, манай улсын ёс зүйн боловсролын тогтолцоог шинэчлэхэд хэрэгтэй загвар, арга зүйг олж харах нь чухал болно.

• • • **Ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн боловсролын тогтолцооны талаархи судалгаа.** Энэ удаа Азийн өндөр хөгжилтэй орнууд болох БНСУ, Япон, БНХАУ-ын ёс зүйн боловсролын тогтолцооны бүтэц, агуулгыг авч үзлээ. **БНСУ-ын хувьд** "Ёс зүйн хичээл"-ийн талаар үндэсний

нэгдсэн боловсролын хөтөлбөрт тодорхой заасан байдаг. Энэхүү үндэсний нэгдсэн боловсролын хөтөлбөрт бага сургуулийн нэгдүгээр ангиас ахлах анги хүртэлх ёс зүйн боловсролыг нэг багц болгон сурагчдад эзэмшүүлэх үндсэн шаардлагатай боловсролын агуулгыг төлөвлөж боловсруулсан байна.

Хүснэгт-1. БНСУ-ын ёс зүйн боловсролын тогтолцоо

|                                    | Бага сургууль                         | Дунд сургууль           | Ахлах сургууль                                                   |
|------------------------------------|---------------------------------------|-------------------------|------------------------------------------------------------------|
| Анги                               | 1, 2                                  | 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10 | 11, 12                                                           |
| Ёс зүйн боловсролд хамаарах хичээл | “зөв амьдрал”                         | “ёс зүй”                | “иргэний ёс зүй”<br>“ёс зүй ба үзэл бодол”<br>“уламжлалт ёс зүй” |
|                                    | Үндэсний нэгдсэн боловсролын хөтөлбөр |                         | Ахлах ангийн сонгон суралцах боловсролын хөтөлбөр                |

эх сурвалж: БНСУ-ын боловсролын бодлогын судалгааны хүрээлэн (2004) “ёс зүй-тусгай сургалт хүмүүжлийн ажлын программыг сайжруулах талаарх судалгаа” pp.9

Дээрх хүснэгтээс харахад, ёс зүйн хичээл нь “Үндэсний нэгдсэн боловсролын хөтөлбөр”-ийн нэгэн салшгүй хэсэг болж, бүх ангид заахаар төлөвлөгдсөн байдаг. Үүнээс гадна сургалт хүмүүжлийн нийт үйл ажиллагаагаар дамжуулан ёс зүйн боловсролыг хэрэгжүүлдэг. Мөн I-II ангид ёс зүйн хичээл болон төрөлх хэлний хичээлийг нэгтгэсэн “зөв амьдрал,” XI-XII ангид сонгон суралцах хичээлээр “иргэний ёс зүй”, “ёс зүй ба үзэл бодол”, “уламжлалт ёс зүй” гэсэн хичээлүүд төлөвлөгдөж дээрх ёс зүйн хичээлтэй сэдэв, агуулга нарийн уялдсан байдаг.

**Япон улсын хувьд** ёс зүйн боловсрол нь “ёс зүйн цаг”-ийг гол тулгуур болгон, сургалт хүмүүжлийн нийт ажлаар хэрэгждэг. Сургуулийн ёс зүйн боловсролын талаар сургалтын ерөнхий стандартад тусгай бүлэг болгон зааж, бага сургууль, дунд сургуульд “ёс зүйн цаг” жилд 35 нэгж цаг ордог. Нэгж хичээлийн цаг нь бага сургуульд 45 минут, дунд сургуульд 50 минут байдаг. Уг ёс зүйн цаг нь суралцагчид өөрсдийн амьдрал, туршлагаас мэдэрсэн, бодсон зүйлээ нэгтгэж, илтгэж, ярилцаж, хэлэлцэх замаар өөрөөс нь ялгаатай бусад

хүний үзэл бодлыг сонсож, хамтдаа тунгаан бодож дүгнэлт гаргах цаг юм. Сургууль болгонд ёс зүйн хичээл заах цаг харилцан адилгүй байдаг ч дунджаар долоо хоногт 1 нэгж цаг төлөвлөж, сургалтыг БШУЯ-аас батлан, ЕБС-ийн сурагчдад зориулан үнэгүй тараагддаг “сэтгэлийн ном” /бага, дунд ангийханд зориулсан цуврал/ болон бусад ёс зүйн боловсролын гарын авлага, материалууд, дуут болон дүрст бичлэг, практик дадлагатай хослуулан багш өөрөө санаачлан шинэлэг арга хэлбэрээр явуулж хэвшсэн байдаг нь сурагчдын сонирхолыг татсан үр дүнтэй сургалт болдог.

Хүснэгт-2. Япон улсын ёс зүйн боловсролын тогтолцоо

|            | Бага сургууль | Дунд сургууль |
|------------|---------------|---------------|
| Анги       | 1 2 3 4 5 6   | 1 2 3         |
| Тусгай цаг | Ёс зүйн цаг   | Ёс зүйн цаг   |

Эх сурвалж: 2008 оны Японы боловсролын стандартад тулгуурлан авч үзлээ.

Бүх сургуульд сургуулийн захирлын удирдамж доор ёс зүйн боловсролыг хариуцсан багшийг томилж, нийт багш нар хамтран ёс зүйн боловсролын нэгдсэн төлөвлөгөө, ёс зүйн цагийн жилийн хөтөлбөр, удирдамж боловсруулдаг. Энэ ёс зүйн боловсролыг хариуцах багшийн ажил үүргийн талаар боловсролын стандартад нарийвчлан зааж өгсөн байдаг нь онцлог бөгөөд илүү үр дүнтэй болгодог юм. Үүнээс гадна, бусад хичээлтэй ёс зүйн хичээлийг харилцан уялдуулж, “Гэр ахуй”, “Нийгэм судлал” зэрэг хичээл, “Төсөлт ажил” болон хичээлээс гадуурх тусгай сургалт хүмүүжлийн ажлаар хүүхдийн ёс суртахууны зан байдлыг төлөвшүүлэхэд анхаардаг. Мөн сургуулийн харъяа хот, дүүрэг болон сурагчийн эцэг эхтэй хэрхэн хамтран ажиллах талаар боловсролын стандарт болон сургуулиудын ёс зүйн боловсролын хөтөлбөрт тусгайлан зааж өгдөг.

**БНХАУ-ын хувьд** бага сургуульд “Ёс зүй, зөв амьдрал”, дунд, ахлах сургуульд “Ёс зүй, нийгэм” гэсэн хичээлүүдийн агуулгаар ёс зүйн боловсрол олгодог байна. Бага сургуулийн “Ёс зүй, зөв амьдрал” хичээл нь долоо хоногт нэг цаг байдаг. Дунд, ахлах сургуулийн “Ёс зүй, нийгэм” хичээл нь долоо хоногт 2 цаг, нийгмийн практик хөдөлмөр, технологийн сургалт ахлах сургуулийн I-II ангид нэг долоо хоног, III ангид 2 долоо хоног заадаг байна.

### Хүснэгт 3. БНХАУ-ын ёс зүйн боловсролын тогтолцоо

|                  | Бага сургууль       | Дунд, ахлах сургууль |
|------------------|---------------------|----------------------|
| Анги             | 1 2 3 4 5 6         | 7 8 9 10 11 12       |
| Холбогдох хичээл | ёс зүй, зөв амьдрал | ёс зүй, нийгэм       |

эх сурвалж: БНХАУ-ын боловсролын бодлогын судалгааны хүрээлэн (2004) "ёс зүй-тусгай сургалт хүмүүжлийн ажлын хөтөлбөрийг сайжруулах талаарх судалгаа" pp.26-30-д тулгуурлан авч үзэв.

Бага сургуулийн "Ёс зүй, зөв амьдрал" хичээл нь эх орон, ард түмэн, хөдөлмөр, шинжлэх ухаан, нийтийн өмчийг хайрлах талаар, нийгмийн түгээмэл ёс суртахууны хэм хэмжээний боловсрол болон улс төр, хувь хүн, хамт олон, эх орны талаар мэдлэг олгож ёс суртахууныг төлөвшүүлэх, сэтгэл зүйн мэдрэмжийг хөгжүүлэх, ёс суртахууны зан үйлийг хэвшүүлэх зорилготой. Дунд сургуулийн "Ёс зүй, нийгэм" хичээл нь нийгмийн ёс суртахууны үндсэн зарчим буюу иргэний эрх, үүрэг, нийгмийн хөгжлийн жам ёсны талаар сургаж, эх орны бүтээн байгуулалтанд өөрийн хувь нэмэр оруулахад хэрэгтэй мэдлэг олгоход чиглэгддэг.

Мөн сурагчдад улс төрийн эрх барих намын удирдамж, өөрийн орны нийгмийн талаарх итгэл үнэмшил, ёс суртахуун, хууль ёс, эх орон, хөдөлмөрийн талаарх мэдлэг, хамт олонч үзэл санаа төлөвшүүлэх суурийг тавьж, хариуцлагатай, сайн, муу зан үйлийг ялгах чадвартай иргэнийг хүмүүжүүлэх зорилго тавьдаг. Үүнээс гадна төрөлх хэлний хичээл нь "бодит үзэл санаа, улс төр, ёс суртахууны талаар", газар зүйн хичээл нь "хүн ам, ашигт малтмал, байгаль орчны талаарх төрийн гол бодлогыг тайлбарлаж, эх оронч хүмүүжил олгох", дунд сургуулийн соёл урлагийн хичээл нь "эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх" зорилготой байдаг.

**Ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн боловсролын агуулгын талаархи харьцуулсан судалгаа.** БНСУ-ын хувьд "Ёс зүй" хичээлийн зорилго нь Солонгос хүний хувьд сайн сайхан амьдрахад хэрэгтэй ёс зүйн хэм хэмжээ болон дэг жаягыг эзэмшүүлж, өдөр тутмын амьдралд тулгарах ёс суртахууны

асуудлыг зүй зохистой шийдвэрлэхэд нөлөөлөх, зарчимч туйлбартай шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ иргэний ухамсар, эх оронч үндэсний сэтгэлгээ, амьдралын утга учир, зарчим, үнэ цэнийг мэдэрч, амьдралд хэрэгжүүлэх чадварлаг иргэн болгон төлөвшүүлэхэд хэрэгтэй ёс суртахууны зан үйлийг хэвшүүлэхэд чиглэгддэг.

Ёс зүйн хичээлийн агуулга нь дараах үндсэн дөрвөн сэдэвт хуваагддаг.Үүнд:

- Хувь хүний амьдрал
- Гэр бүл, хөрш, сургуулийн амьдрал
- Нийгмийн амьдрал
- Улс орон, үндэсний амьдрал эдгээр болно.

Эдгээр сэдвийн хүрээнд бага сургуулийн III ангиас эхлээд X анги хүртэл эзэмшүүлэх ёс суртахууны хэм хэмжээг тодорхойлдог. Мөн энэхүү хичээлийн заах агуулга, залгамж холбооны асуудлыг нарийн уялдуулан зохицуулж, хүүхдийн насны онцлогыг харгалзан тухайн ангид онцгойлон зааж сургах шаардлагатай хэм хэмжээг тогтоодог байна. Тухайлбал, бага сургуулийн III-IV ангид “хувь хүний амьдрал”, “гэр бүл, хөрш, сургуулийн амьдрал”-д хамаарах ёс суртахууны хэм хэмжээний талаарх олон асуудлыг сэдэвчлэн оруулсан байдаг бол, V-VI ангид “нийгмийн амьдрал”, “улс орон, үндэсний амьдрал”, VII-IX ангид “хувь хүний амьдрал”-д хамаарах хэм хэмжээний талаар илүү анхаарч, харин X-XI ангид зөвхөн “хувь хүний амьдрал”, “гэр бүл, орчин тойрон, сургуулийн амьдрал”-д хамаарах сэдвүүд багтдаг байна.

**Япон улсын хувьд** сургуулийн өмнөх шатны боловсрол буюу цэцэрлэгийн насны хүүхдээс эхлээд, бага, дунд, ахлах сургуульд төлөвшүүлэх шаардлагатай ёс зүйн хэм хэмжээний талаар сургалтын стандартад тодорхой заасан байдаг. Бага, дунд сургуулийн “ёс зүйн цаг” болон сургалт хүмүүжлийн ажлаар дараах хүснэгтэнд буй ёс суртахууны дөрвөн гол хэм хэмжээг заадаг.

Хүснэгт 4. Япон улсын бага, дунд сургуульд заах ёс зүйн хэм хэмжээ (агуулга)

|   | Гол сэдэв                                                           | Агуулга                                                                                                                                                                                                                                                                                                     |
|---|---------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Хувь хүнд өөрт нь хамаарах ёс суртахууны хэм хэмжээ                 | Эрүүл мэнд, аюулгүй байдал, зохистой амьдралын хэмнэл, тууштай байх, хүсэл тэмүүлэлтэй, зоригтой байх, сайн, мууг ялгах, бие даах чадвартай байх,<br>үнэнч, өөдрөг, илэн далангүй байх, өөрийн сайн талыг хөгжүүлж, муу талаа засах гэх мэт                                                                 |
| 2 | Бусад хүмүүстэй харилцахад хамаарах ёс суртахууны хэм хэмжээ        | нийгмийн дэг журам сахих, аливаа юманд сэтгэлээсээ хандах, өрөвч, эелдэг байх, итгэл, нөхөрлөл, бие биедээ туслах, хүнийг хүндэтгэх, талархах, даруу байх, хүлээцтэй хандах гэх мэт                                                                                                                         |
| 3 | Байгаль орчин болон хүндлэн дээдлэх ёстой зүйлд хамаарах хэм хэмжээ | амь насны үнэ цэнэ, өөрийн болон бусдын амь насыг хайрлах, хүндлэх, байгаль, ан амьтан хамгаалах,<br>сэтгэл хөдлөх, бишрэх зэрэг                                                                                                                                                                            |
| 4 | Хамт олон, нийгмийн харилцаанд хамаарах ёс суртахууны хэм хэмжээ    | бусдад өгсөн амлалт, нийгмийн дэг журмыг баримтлах, нийгмийн ёс зүйг сахих, эрх, үүргээ мэддэг байх, шударга, эрх тэгш байдал, өөрийн үүргээ ухамсарлах, хариуцлага, бусдад туслах сэтгэл, гэр бүлээ хайрлах, сургуулиа хайрлах, эх орноо хайрлах,<br>олон улсын байдлыг ойлгох, дэлхийн энх тайван гэх мэт |

эх сурвалж: Токио хот, Итабаши дүүргийн боловсролын комиссын “ёс зүйн нээлттэй хичээлийн материал”. 2008.10.15

Эдгээр дөрвөн гол агуулгад тулгуурлан, хүүхдийн нас, сэтгэхүй, сэтгэл зүйн хөгжлийн онцлогт тохируулан, бага, дунд сургуулийн хүмүүжлийн ажлын зорилгыг тодорхойлж, тодорхой төлөвлөгөөтэйгөөр ёс зүйн боловсролыг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, бага сургуулийн сургалтын стандартад зааснаас харахад, бүх сургуульд бие даах чадвартай, бусдын болон өөрийн амь насыг хайрлах сэтгэлийг хүүхдэд төлөвшүүлнэ. Үүний зэрэгцээ, хүүхдийн насны онцлогыг харгалзан, эзэмшүүлвэл зохих ёс зүйн хэмжээг тусгайлан тогтооно. Бага ангид хүнтэй мэндлэх, хүнийг хайрлах, хүндлэх зэрэг амьдралын зөв дадал, нийгмийн амьдралын дэг журмыг эзэмшүүлж, сайн, мууг ялгах, хүний ёсонд харш зүйл хийхгүй байх, дунд ангид хамт олон, нийгмийн журмыг сахиж, бусдад туслалцаа үзүүлэх, ахлах ангид хууль, дүрэм журмын утгыг ойлгож, бусдын байр суурийг ойлгох, харилцан дэмжих, нийгэм хамт олны өмнө өөрийн хүлээх үүрэг, хариуцлагыг биелүүлж, эх орныхоо иргэн, нийгмийн нэг гишүүн гэдгээ ухамсарлахад хамаарах ёс зүйн хэм хэмжээний талаар ойлгуулахад анхаарч, сургууль бүрийн бодит байдал, нийгмийн хэрэгцээ, орчинд нийцүүлэн заах арга зүйг боловсруулдаг.

**БНХАУ-ын хувьд** ЕБС – ийн I-YI ангид “Ёс зүй, зөв амьдрал”, YII-XII ангид “Ёс зүй, нийгэм” гэсэн хичээл заадаг. Ёс зүйн боловсролын зорилго, агуулгыг анги тус бүрээр заасан байдаг. Тухайлбал, I-II ангид хүн бүр ёс жаягийг хүндэтгэж сахих, III-Y ангид ядуу гэр бүл, гамшигт автсан иргэд зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст анхаарал хандуулж хүнд туслах, бусдын хүсэл сонирхлыг анхаардаг болгоход голлон анхаарсан ёс зүйн хэм хэмжээний талаар заадаг.

Мөн нэгдүгээр ангийн “Ёс зүй, зөв амьдрал” сурах бичгээс харахад анх сургуульд орсон хүүхдүүд эхний жилдээ аав ээжийгээ хайрлах, өвөө эмээдээ сайн хандах, дэг жаягтай зөв үг хэллэг хэрэглэх, томоотой намдуу байх, үймж шуугихгүй байх, зоригтой байх, худлаа хэлэхгүй байх, өөрийнхөө юмыг өөрөө хийх, ахуйн эд хэрэглэлээ хайр гамтай хэрэглэх, байгаль орчинг хамгаалах, эрүүл ахуйг сахих, өвс ургамлыг хайрлах, сургуулийн дүрмийг биелүүлэх талаар суралцдаг.

• • • III ангийн сурах бичгээс харахад, ажил хөдөлмөрийг нэр төрийн хэрэг гэж бодох, залхуурахыг ичгүүртэй хэрэг гэж тэвчих, ээждээ туслах, бие сэтгэлээ төвлөрүүлэх, хамт олны ажил хэрэгт идэвхтэй оролцох, хамт олныхоо төлөө сайн зүйл хийх, найз нөхөд зовлонд унасан үед туслах, үндэсний уламжлалаа

дээдлэх тухай, харин дунд ангийн сурах бичигт ёс зүйн хэм хэмжээнээс гадна, эртний Хятадын үлгэр туульс, гадаад орны түүх, улмаар Хятад улсыг бүтээн босгоход гавъяа байгуулсан хүмүүсийн үлгэр дуурайллаас суралцах тухай сэдвүүд нэмэгддэг. Үүнээс анги ахих тусам хамрах хүрээ, агуулга нь гүнзгийрэн баяжиж байдгийг харж болно. Тухайлбал, YI ангийн сурах бичиг унших сэдэв ихтэй, өдөр тутмын амьдралын дэг журам, улмаар өөрийгөө захирах ба урамшуулах, олны дунд биеэ зөв авч явах, бусдад тус хүргэхийн утга учрын талаар заадаг. Сурах бичгийн сэдэв нь бие хүн болон гэр бүлийн амьдралд мөрдөх ёс зүйн хэм хэмжээ гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Энэ мэтээр анги тус бүрд ялгавартай заах ёс зүйн боловсролын агуулгыг үндсэнд нь дараах таван бүлэгт хуваан ангилдаг. Үүнд:

①Хүндэтгэж хайрлах ёстой “таван хайр” (эх орон, ард иргэд, хөдөлмөр, шинжлэх ухаан, нийгэм), “таван онол”(соёл иргэншил, ёс жаяг, эрүүл ахуй, дүрэм журам, ёс суртахуун), “дөрвөн гоо зүй” (сэтгэл, үг хэл, үйл хөдөлгөөн, байгаль орчин)②

- ёс зүйтэй, эрүүл зөв зан ааштай хүнийг төлөвшүүлэх, сэтгэлийн хаттай болгох, хүн чанартай болгох,

- хуулийн талаар мэдлэг олгох, насанд хүрээгүй хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалж, эх орныхоо аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар мэдлэг боловсрол олгох, улс төрийн ухамсар төлөвшүүлэх,

- төрийн бодлогын талаарх мэдлэг боловсрол олгох, нийгмийн хураангуй түүх, нийгмийн хөгжлийн зүй тогтлын түүх

- диалектик материалист үзэл эдгээр болно.

Суралцагчдад харилцааны соёл эзэмшүүлэх, өөртөө болон бусдад хүндэтгэлтэй хандах, биеэ зөв авч явах, хүнлэг тусч байх зэрэг зан чанарыг төлөвшүүлэхэд эдгээр орнуудын туршлагаас суралцах зүйл багагүй бий.

Юуны өмнө, ёс зүйн боловсролын нэгдсэн тогтолцооны талаар бид бодох хэрэгтэй. Ёс зүйн боловсрол нь бага ангиас эхлээд ахлах ангийн суралцагч хүртэл зайлшгүй мэдвэл зохих асуудлуудыг багтаасан нарийн боловсруулсан хөтөлбөрийн дагуу хэрэгжиж байх ёстой. Мөн ёс зүйн боловсролын агуулгыг бусад хичээлийн хөтөлбөртэй холбож уялдуулж чадвал илүү үр дүнд хүрэх болно.

Манай орны хувьд ёс зүйн боловсролын хөтөлбөр, стандарт, төлөвлөгөө байхгүй байгаа өнөөгийн нөхцөлд олон төрлийн хичээлийн хөтөлбөрт ёс зүйн талаар бага ч гэсэн мэдлэг олгож байгаа ч хоорондын уялдаа холбоо /хичээл

хоорондын интеграци / туйлын дутмаг тул ёс зүйн боловсролын тогтолцоог бий болгож чадаагүй байна. Дээр дурдсанчлан, Японд албан ёсны дүн тавихгүй тусгай ёс зүйн цагаар, Солонгос, Хятадад дүнтэй бие даасан хичээлээр ёс зүйн боловсрол олгож байна. Эдгээр орнуудын ёс зүйн боловсролын тогтолцоо нь бие даасан хичээл, эсвэл тусгай хөтөлбөрт цагтай, нэгдсэн боловсролын хөтөлбөрт тусгаж өгсөн тогтвортой, шат дараалсан системтэй ёс зүйн боловсролын загвар юм.

Манай улсын хувьд бага, дунд сургуульд үзэх хичээлийн тоо олон, мөн бусад хичээл дунд ёс зүйн талаар дурдаж байгаа тул, дахин шинэ бие даасан хичээл нэвтрүүлэх шаардлагагүй гэсэн санал байж болох юм. Энэ тохиолдолд цаашид бид Солонгос шиг бие даасан хичээлээр заахгүй ч гэсэн, Япон шиг тусгай хөтөлбөрт цаг гаргаж заах нь зүйтэй. Гэхдээ өнөөгийн нөхцөлд хөтөлбөртэй цаг тусгайлан боловсруулж заах сургалтын орчин, нөхцөл хараахан бүрдээгүй байна. Ийм нөхцөлд, төсөлт ажил, иргэний боловсрол, сургуулийн зохицуулах цагийг ангийн хурал, давтлага, цэвэрлэгээний цаг биш, сургалтын стандартанд заасан зорилгынх нь дагуу бүрэн дүүрэн ашиглахад анхаарч, эдгээр цаг дотор ёс зүйн тусгай хөтөлбөрт хичээл оруулах шаардлагатай юм.

Эдгээр цаг буюу хичээлээс гадуурх сургалтын ажил нь боловсролын стандартад зааснаас харахад нийгэмтэй харилцах зөв хандлага, иргэний нийгэмд ажиллаж амьдрах чадвар дадал олгоно гэж заасан байдгаараа ёс зүйн боловсролд ач холбогдолтой юм. Гэтэл бодит байдалд хичээлээс гадуурх сургалтын ажил энэ зорилгоо биелүүлж чадахгүй байгаа. Мөн суралцагчдынхаа хүмүүжил төлөвшил, биеэ авч яваа байдал, ёс суртахууны дутагдал зэргийг харгалзан, сурах бичигт бичигдээгүй ёс зүйн хэм хэмжээний талаар багш өөрөө санаачлан сургалтын материал боловсруулж хичээлдээ хэрэглэж занших шаардлагатай байна.

Энэ мэт олон асуудлыг судалж, асуудалд ажил хэрэгч хандахыг биднээс цаг үе шаардаж байна. Бидэнд боловсролын шат бүрийг хөндлөн холбосон ёс зүйн боловсролын үзэл санаа, агуулгыг цэцэрлэгийн наснаас эхлэн хүүхэд суралцагчийн нас, сэтгэхүй, сэтгэл зүйн хөгжлийн онцлого, тухайн сургуулийн сургалтын орчин зэрэг хүчин зүйлд тулгуурлан системтэйгээр тууштай заахаар сургалтын хөтөлбөрт тодорхой тусгаж, амьдралд хэрэгжүүлж буй дээрх азийн орнуудаас санаа авууштай зүйл олон бий.

Дээрхи судалгаанаас үзвэл, ёс зүйн боловсролын агуулгад олон талт зарчмыг баримталсан, прагматик, үр дүнг чухалчилсан тийм сургалтын хөтөлбөр, ном, сурах бичиг боловсруулах хэрэгтэй. Энэхүү харьцуулсан судалгааны үр дүнд манай улсын ЕБС- д ёс зүйн боловсролын агуулга дараах бүтэцтэй байх нь зохистой гэж үзэж байна. Үүнд бага ангид зөв амьдрах анхан шатны боловсролыг олгох, дунд ангид гэр бүлдээ болон нийгэмд биеэ зөв авч явах ёс журмыг голлон заах, ахлах ангид албан харилцааны ёс зүйн хэм хэмжээг, мөн иргэний ёс зүйг заах нь зохистой юм.

Цаашид ЕБС-ийн суралцагчдад олгож буй ёс зүйн боловсролын агуулга, заах арга зүйн талаар үндэсний хэмжээний семинар зохион байгуулж, эрдэмтэн судлаачид олон талаас нь нухацтай хэлэлцэн, хамтын хүчээр ойрын үед цаг алдахгүйгээр ёс зүйн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр боловсруулж, үндэсний /монголын/ онцлогтой ном, сурах бичиг, гарын авлага бичих шаардлагатай байна.

### Дүгнэлт

Өнөөгийн манай улсын ёс зүйн боловсролын гол зорилго нь ёс суртахууны хувьд боловсорсон хүнийг төлөвшүүлэх явдал юм. Ёс зүйн боловсролын тогтолцооны хувьд ЕБС - ийн 12 жилийн албан ёсны бие даасан хичээл байх хэрэгтэй. Ёс зүйн боловсролын үндсэн агуулгад хувь хүний өдөр тутмын амьдралын ёс жаяг, иргэний ёс зүй, гэр бүлийн ёс зүй, нийгмийн харилцааны ёс зүйн асуудлуудыг түлхүү судлуулах нь илүү үр өгөөжтэй байх болно гэж үзэж байна. Ёс зүйн боловсролын эцсийн үр дүн бол хувь хүний ёс суртахууны хөгжлийг хангах явдал мөн.

## Ном зүй

- Р.Дарьхүү. Г.Нарантуяа. Ёс зүй. V анги. УБ., 1998
- Р.Дарьхүү. З.Цэндсүрэн. Эрхэмлэх ёс УБ., 2007
- Япон улсын боловсролын бодлогын судалгааны хүрээлэн. "Ёс зүй-тусгай сургалт хүмүүжлийн ажлын программыг сайжруулах талаарх судалгаа", 2004 он
- Японы Боловсрол шинжлэх ухааны яам. "Бага сургуулийн сургалтын стандарт". 2008 он 6 сар
- "Солонгосын анхан дунд шатны боловсролын үндэсний стандарт". Солонгосын сурах бичиг хэвлэлийн компани. 1998 он
- Сүгихара Сэйширо "Солонгосын ёс зүйн боловсролоос суралцах нь"- Бункашобо хакүбүн хэвлэлийн компани. 2007.10 сар
- Японы боловсрол шинжлэх ухааны яам. "Бага сургуулийн сургалтын стандартын тайлбар". Тоёокан хэвлэлийн компани, 2008.08 сар
- John Wilson. "The moral education of the world". Тамагава их сургуулийн хэвлэл, 2002.4 сар